



## БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ БА ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

### БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Бүс нутгийг эдийн засгийн хөгжлийн загвар болгохуйц тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч, бүс нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах.

### ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Хүн амын тоо өсөн нэмэгдсэнээр (Азийн Хөгжлийн Банкны тооцоноор Ханбогд суманд 2020 он гэхэд 20,000 хүн шинээр суурьшина) доорхи зүйлсэд ачаалал, дарамт үзүүлэх юм:
  - Дэд бүтэц
  - Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ
  - Хог хаягдлын үйлчилгээ
- Байгалийн нөөц болон бэлчээрийн ачаалал нэмэгдэх.

### БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

- Орон нутгийн төлөвлөлтийн үйл явцтай уялдуулан Өмнийн Говийн бүс нутгийг эдийн засгийн тогтвортой хөгжилд бэлтгэх болон дэмжихэд чиглэгдсэн бодит үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.





#### БҮС НУТГИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ:

- Өмнийн Говийн Бүсийн Хөгжлийн Зөвлөл зэрэг орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллаж бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, Оюу Толгойн Орон нутаг, бүсийн төлөвлөлт ба дэд бүтцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Ханбогд сумын төвийн усны шинэ эх үүсвэрийг хайх, шинээр хог хаягдлын менежментийн байгууламж байгуулах, Оюу Толгойгоос Ханбогд сум хүртэл эрчим хүчний шинэ шугам татах зэрэг шинэ болон сайжруулсан дэд бүтцэд дэмжлэг үзүүлэх
- Улсын болон орон нутгийн захиргаатай хамтран нийтийн дэд бүтэц болон үйлчилгээг хөгжүүлэх болон ханган нийлүүлэх ажлыг зохицуулах
- Оюу Толгойн бүсийн хөгжил, орон сууцны асуудлаар дэмжлэг үзүүлэх замын зураг болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах.

#### ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ:

- Орон нутаг, бүс нутгийн ажиллах хүчинд давуу эрх олгон ажиллуулах
- Орон нутгийн бараа, үйлчилгээний худалдан авалт болон нийлүүлэлтийг өргөжүүлэх
- Орон нутгийн бизнес, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр болон бусад хөгжлийн санаачилгуудаар дамжуулан орон нутгийн ханган нийлүүлэлтийн сүлжээг үргэлжлүүлэн дэмжих.

#### НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

- Өмнөговь аймгийн эрүүл мэндийн зөвлөх төвд дэмжлэг үзүүлэх болон Эмчийг ивээн тэтгэх зэрэг хөтөлбөрөөр дамжуулан орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэхэд туслах
- Их дээд сургуульд суралцах тэтгэлэг, Ханбогд сумын төвийн цэцэрлэгийн өргөтгөл зэрэг үйл ажиллагааны хүрээнд боловсролын үйлчилгээ, байгууламжуудыг дэмжих үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөлийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г [www.ot.mn](http://www.ot.mn) цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.